

**Нүүдэлчдийн нийгмийн харилцааны түүхийн асуудалд**  
(Хүннүгийн жишээн дээр)

*Доктор /PhD/, дэд профессор З.Батсайхан*

Төв Азийн эртний нүүдэлчдийн олон гол зангилаа асуудалтай Хүннү нар зүй ёсоор холбогдохоос гадна Хүннүгийн баримт сэлт нь дорно дахины судлалын олон чухал сэдвийг шийдвэрлэхэд ихээхэн ач холбогдолтой болох нь маргаангүй. Эдүгээ Хүннү судлал нэн идэвхжиж байгаа хэдий ч нүүдэлчдийн хөгжил хар зөнгөөрөө явагддаг гэх мэт олон маргаан одоо ч үргэлжилсээр байгаа юм. Судлаачид янз бүрийн угсаатны хэрэглэгдэхүүн дээр үндэслэн уг асуудлыг судлах хэд хэдэн арга замыг боловсруулаад байгаа боловч хүннүгийн баримт сэлт дээр нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн түүхэн реконструкц хийгдээгүй бөгөөд үүний шалтгаан нь манай судалгаа арга зүйн хувьд боловсруулагдаагүйтэй холбоотой бизээ. Нөгөө талаас нүүдэлчдийн төр улс, социал харилцааны онцгой хэв шинж нь боолын ба феодалын төр улсын бүтэц түүний сонгодог хувилбаруудын аль алинд нь багтдаггүй (Першиц 1976, Куббель 1988, Крадин 1994, Хавх 1996) бөгөөд нэг хүний засаглал нь овгийн ба социал харьцаа, албатын харилцааны нарийн түвэгтэй тогтолцооны хослол болдог ажээ. (Мартынов 1998:237) Сүүлийн жилүүдэд шинжлэх ухааны сэтгэлгээ чухамхүү энэ чиг хандлагаар урагшлан хөгжиж байна.

Хүннүгийн нийгмийн харилцааны түүхийг судлах гол сурвалж нь эртний хятадын түүхэн тэмдэглэлүүд болон археологийн сурвалж болох бөгөөд, ялангуяа, сүүлийн жилүүдэд нилээд их шинэ хэрэглэгдэхүүн хуримтлагдсан. Гэвч малталт судалгааг зохион явуулахдаа зөвхөн тоногдоогүй болов уу гэж үзсэн булшуудыг судлах арга зүйг гол болгож, тухайн оршуулгын газрын зохион байгуулалтанд төдийлөн анхаардаггүй байсан нь олон чухал асуудлыг судлах боломжийг алдсан гэсэн үг. Үүнийг үл өгүүлэн өөрийн мэдэлд буй баримт сэлтэд түшиглэн Хүннүгийн нийгмийн зарим асуудлыг авч үзье.

Сыма Цянь, Хүннү нарын тухай: 1) тэдний гэрийн малаас хамгийн олон нь адуу, үхэр, хонь гээд цааш нь нум татаж чадах насанд хүрсэн эр бүр хуягт цэрэг болдог. 2) (Таскин) тайван цагт мал даган нүүдэллэн явдаг гэх мэтээр Хүннү нарыг хятад сурвалжид тулгуурлан тодорхойлсон байна.

Үүнээс үзвэл Хүннү нарын үйлдвэрлэлийн үйл ажиллагааны хүрээнд мал аж ахуй зонхилох байр суурийг эзэлж байгаа боловч нүүдлийн аж ахуйн тогтвортой байдал нь эдийн засгийн өөрчлөлтөөр тодорхойлогдож байдаг. Өөрөөр хэлбэл мал сүрэг нь цаг агаарын өөрчлөлт болон гадны хандлага довтолгоонд хамгийн түрүүнд өртдөг тул нүүдэлчин малчдын хувьд илүүдэл бүтээгдэхүүн бий болгох боломж нь газар тариалан ба газар тариалан-мал аж ахуй эрхлэгчидтэй харьцуулахад бага, найдвар муутай байдаг (Першиц 1976:288,289).

Үйлдвэрлэх хүчний хөгжилд тодорхой хязгаар байх ба түүнийг технологийн шинэчлэл хийхгүйгээр даван туулах боломжгүй. Зарим нэг эртний нийгмийн натураль үйлдвэрлэх хүчний тогтолцооны хүрээнд технологийн өөрчлөлт маш бага байсан бол нүүдэлчдийн хувьд мал аж ахуйтай холбоотой цөөн тооны хөдөлмөрийн багаж зэвсэг нь эртнээс эдүгээ хүртэл бараг өөрчлөгдөөгүй ажээ (Крадин 1994:64, Хавх 1996).

Нүүдэлчдийн нийгмийн хөгжил нь зөвхөн эдийн засгийн өөрчлөлт төдийгүй хөдөлмөрийн хуваарь ба хоршоололтой холбоотой. Иймээс эртний улсуудад анги үүсэн бүрэлдэх нэгэн чухал хүчин зүйл нь аян дайн, тодруулбал цэрэг дайны үйл ажиллагаагаар мэргэжих, цэргийн удирдлагын эрхийг хууль бусаар булаан авах явдал юм (Першиц 1976: 293-295, Кубель 1988:126-129). Тухайлбал, Маодун түмтийн дарга болсны хойно дуут годилоор эцэг Түмэнг харван алж шаньюй болсныг дурдаж болохоос гадна цэрэг дайны үүрэг нэмэгдэж, түүгээр мэргэшсэн хэсэг бүлгүүд хэдийнээ бий болсон бөгөөд Хүннү нар дайн байлдааныг өөрсдийн гол ажил гэж илэрхий үздэг байлаа. (Таскин 1968) Гэхдээ уул зөрчлийн уг сурвалж нь шаньюйн ор суух, үе

залгамжлалтай холбоотой байсан өөрөөр хэлбэл наад зах нь Түмэн шаньюйн үед Хүннүд эцгээс хүүд шилждэг улс төрийн засаглалын тодорхой элемент, институт (журам) хэлбэршин тогтож, түрүү төр улсын нэгдэл-чифдом үүссэнийг харуулж байна. Энэ нь Хүннүд төр улс үүсэх хүчин зүйлийн нэг болжээ.

Хүннү эр бүр аян дайнд оролцох ёстой бөгөөд хятад сурвалжид өгүүлснээр нум татаж чадах насанд хүрсэн эр бүр хуягт морин цэрэг болдог байсан ба Монгол, Өвөр Байгальд явуулсан археологийн судалгаанаас үзвэл бараг эр хүн бүрийн булшинд зэр зэвсгийн зүйлийг дагуулан оршуулсан байна. Үүнээс гадна эр зориг, баатарлаг гавъяагаараа алдаршсан дайчин эрийн тухай домог яриа тал нутгийн нүүдэлчдийн дунд дэлгэрч байсны нэг нь мөнөөх Маодун шаньюй юм. Вэй улсын түүхэнд: ухуаны Тадун баатар зоригтой дайчин эр байсан тул хил орчим суух хүндэт настангууд түүнийг Маодунтай зүйрлэн үздэг байлаа (Таскин 1984:83). Энэхүү мэдээ нь Маодунаас хойш даруй 400 орчим жилийн дараа болж буй үйл явдал бөгөөд нүүдэлчдийн дунд энэ мэт олон домог яриа байсан нь эргэлзээгүй. Түүнчлэн түрэг монгол нүүдэлчдийн баатарлаг туульсийн үүсэл хөгжил дүрийг судлах сонирхолтой баримт байж болно.

Хүннү нарын дотор эд хөрөнгийн ялгаа гарсан тухай сурвалжид ямар нэг мэдээ заалт үгүй боловч нүүдэлчдийн дотор янз бүрийн статус бүхий цэрэг эрс байжээ. Хүннүгийн цэрэг нь дан морин цэргээс бүрдэж байсан боловч хөнгөн зэвсэгт шилдэг дайчид (Таскин 1968:82) хуягт цэрэг, (Таскин 1968:87) шуурхай салаа, морьт тагнуул (Таскин 1968:47) гэх мэт зохион байгуулалтад орсон улсын цэргийн зэрэгцээ түгшүүртэй цагт морь унаж харвах, намнах сургууль хийж, тайван цагт хийх юмгүй зугаацдаг (Таскин 1968:46) нүүдэлчин-цэрэг эрс байсан бөгөөд тэд аян дайны үед аравтын зохион байгуулалтанд орж, цэргийн гол хүч болдог байжээ. Сурвалжид дурьдсанаар аян дайнд оролцсон хүннүгийн цэргүүдэд булаан авсан эд зүйлийг (аль нэг түшмэл) хувиарлан өгдөг байсан мэтээр сурвалжид бичсэн байдгаас (Таскин 1968:41) үзвэл "албан тушаал"-ыг нь харгалзан их, багаар хувь хүртээдэг бололтой бөгөөд энэ нь эд хөрөнгийн ялгаа бий болоход тодорхой хэмжээгээр нөлөөлсөн байж болох юм.

Хүннүгийн нийгэмд гарсан эд хөрөнгийн тэгш бус байдал, социал бүтцийн ялгааг харуулах жишээг археологийн хэрэглэгдэхүүнээр бий болгох бололцоотой байдаг. А.В. Давыдова олон жилийн турш Иволгийн суурин болон оршуулгын газрыг дагнан малтан судалсан бөгөөд судалгааны үр дүнд Иволгын хүннү булшуудыг дагалдуулсан эд өлгийн чанарын ялгаагаар нь таван категори болгон хуваахын хамт баялаг ба ядуу хоёр туйлын хооронд завсарын нэг үе байгааг дурьдаад энэ категори нь булшны олонхи болж буйг онцлон тэмдэглэсэн байна. Түүнчлэн, энэ олонхи нь олон талтайгаас гадна эд хөрөнгө, нийгмийн ялгааг харуулж байгаа бөгөөд уг ялгаа эрэгтэй хүний булшинд илүү илэрч байна (1996, Т.2:30). Гэвч тэрээр өгүүлэн буй асуудалтай салшгүй холбоотой нэг гол шинж тэмдэг булшны гадаад, дотоод бүтэц, зохион байгуулалтыг төдийлөн ойшоож үзээгүй. Аливаа зүйлийн гадаад хэлбэр нь дотоод агуулгаа ямагт илэрхийлж байдаг. В.М. Массон, эртний булшууд тоногдсон байдгийг харгалзан үзэхийн ялдамд булшны гадаад, дотоод бүтэц зохион байгуулалт нь нас барсан хүний алдар нэр, хөдөлмөр зарцуулалтын хэмжүүр болох зохион байгуулалтын тусгал, археологийн өгөгдөхүүнийг илүү бодитой тайлбарлах үзүүлэлт гэжээ (1994:46).

Археологийн утга зохиолд хүннү булшуудыг язгууртны ба жирийн иргэдийн гэж хоёр ерөнхий ангилдаг боловч энэ нь бодит байдлыг илэрхийлэх үзүүлэлт болж чаддаггүй. Хэрэглэгдэхүүнээс үзвэл язгууртны хэмээх үүдэвч бүхий дөрвөлжин хашлагат булшууд нь ойролцоогоор 10x10-50x50 метр хүртэл хэмжээтэй байдаг бол энгийн буюу жирийн иргэдийн хэмээх дугуй хэлбэртэй булшууд ойролцоогоор 6-25 метр хүртэл хэмжээтэй байхаас гадна эд өлгийн чанар, булшны дотоод бүтэц, зохион байгуулалтаараа дотроо ялгаатай байдаг. К.А.Акишев Или мөрний хөндий дэх сак, үсүний археологийн материалуудыг судлаад 50-105 метр голчтой, 8-17 м өндөр булшийг "хаадын", 30-45 м голчтой, 5-6 м өндөр булшыг сурвалжтаны, 6-18 метр голчтой, 1-2 метр өндөр булшийг энгийн цэрэг дайчдын гэж үзсэн (1963). Манай мэдэлд буй археологийн судалгааны баримт сэлтэд дулдуйдан 20-50 метр дөрвөлжин

хашлагатай булшуудыг шаньюйн, 10-20 м дөрвөлжин хашлагатай булшуудыг сурвалжтан язгууртны, 5-20 м дугуй дараастай булшуудыг энгийн иргэд (нүүдэлчин-цэрэг) гэж болзолт байдлаар ангилж болох юм. Гэвч дээрх ганц шинж тэмдэг хангалтгүй гэдгийг дурдах хэрэгтэй. Маодун шаньюй болмогц баруун зүүн сянь-ван, баруун зүүн кули-ван, баруун зүүн их жанжин, баруун зүүн их дүвэй, баруун зүүн их данху, баруун зүүн гудухоуг тавьжээ. Хүннү хэлээр сэцэн мэргэнийг "туци" гэнэ. Иймээс шаньюйн ахмад хүү зүүн туци-ван болдог. Зүүн баруун сянь-вангаас эхлээд данху хүртэл хүчирхэг нь нэг түмэн морьт цэрэгтэй, дорой буурай нь хэдэн мянган морин цэрэгтэй 24 ахлагчийг вань-ци буюу түмтийн дарга болгосон ба бүгд үе залгамжилна (Таскин 1968:40). Үүнээс үзвэл дээрх 24 түмтийн дарга нар нь хуучны их бага овгуудыг нэгтгэсэн аймгийн ахлагч нар байсан учраас "дорой буурай" хэсгийн цэргийн тоог өсгөн тэгшитгэх зорилго тавиагүй бололтой. Нөгөө талаас овог аймгийн засаглалын уламжлалт бүтэц дээр тулгуурлан, хатуу сахилга баттай цэргийн зохион байгуулалт хэлбэршин тогтоод байсан бөгөөд тэд хуучин овог аймгийн бүтцээр холбогдохын хамт иргэний ба цэргийн үзэл суртлын тэргүүлэл нь хуучин уламжлалаар нөхцөлдөж байсан бололтой. Харин мянгат, зуут, аравтын дарга, болон жижиг түшмэд, дүвэй, данху, цецзю-нарын туслахыг түмтийн дарга нар мэдэж томилдог (Таскин 1968:40) бөгөөд тэд үе залгамжлах эрх эдэлдэггүй байсныг сурвалжийн мэдээ харуулж байна.

Өмнө өгүүлснээр хүннү булшууд язгууртны ба энгийн иргэдийн гэсэн хоёр том бүлэгт хуваагдаж байгаа боловч дотроо үлэмж ялгаатай. Энэхүү ялгаа нь тухайн хүний нийгмийн байдал, социал бүлэг ба эд хөрөнгийн ялгааг тусган харуулах бодит үзүүлэлт болно. Тухайлбал, Ноён уулан дахь том булшууд гадаад хэлбэрийн хувьд ижил ойролцоогоор 1 м өндөр, үүдэвчтэй дөрвөлжин хэлбэртэй байдаг боловч гол ялгаа нь тэдгээрийн хэмжээнд орших бөгөөд үүнийг дагалдан булшны дотоод байгууламж, эд өлгийн чанарын хооронд эрс ялгаатай байдаг. Үүнээс үзвэл зөвхөн Шаньюй төдийгүй хүннүгийн бүх язгууртан олон зэрэг дэв бүхий сайдууд, түмтийн захирагч болон тэдний ураг төрлийнхнийг ийнхүү оршуулж байжээ гэж таамаглаж болно. Энгийн иргэдийн хэмээх дугуй булшуудад мөн дээрхийн ижил ялгаа байдаг бөгөөд хамгийн том булшууд нь их төлөв оршуулгын газрын зүүн урд тэргүүнд байхаас гадна булшны гүн зарим тохиолдолд зүг чиглэлээрээ хүртэл ялгаатай тал ажиглагдаж байгаа нь энэ бүлгээс эрх мэдэл, эд хөрөнгөөрөө ялгарсан хэсэг олонхийн дунд буй болсныг харуулах баримт мөн гэж үзвэл зохилтой ба магадгүй тэдний дотроос мянгат, зуут, аравт болон бусад жижиг түшмэдүүдийг сонгодог байсан нь хүннүгийн нийгэмд нэгэнт эхэлсэн нийгмийн тэгш бус байдлыг улам гүнзгийрүүлсэн бололтой. Хэрэглэгдэхүүнээс үзвэл Эгийн голын 27-р булшнаас 2 хос могой орооцолдуулан хийсэн алтан шармал чимэглэл (Эрдэнэбаатар 1998:101), Дуулга уулын 2-р булшнаас 5 төрлийн шавар ваар, дэнгийн хүрэл цөгц, жадны гилбэр зэрэг эд өлгөөс гадна хувцсанд хадаж байсан бололтой навчин хэлбэрийн нүхтэй жижиг алтан ялтас, мөнгөн товруу зэрэг эд зүйл гарсан. Эдгээр булшууд нь оршуулгын газрын зүүн урд захад байсан ба хэмжээгээр хамгийн том 11-12 м. голчтой байжээ. Дуулга уулын 2-р булш 5 м. гүн, шургааган хашлаганд эр, эм хоёр хүнийг хамт оршуулсан ба дээрх хоёр булш нь хоёул өргөргийн дагуу байрлалтай толгойг нь зүүн зүг чиглүүлсэн байлаа.

Хэрэглэгдэхүүнээс үзвэл хүннүгийн нийгмийн үндсэн хэсэг нь энгийн чөлөөт нүүдэлчид байсан ба энэ нь археологийн материалд тодорхой илэрдэг. Тэд хүннүгийн цэргийн гол хүч нь болохоос гадна зарим нэг чухал алба гувчуурыг төлөгчид байсан бололтой. Намар агт морь тарга тэвээрэг авмагц Дайлинд их хуралдай хийж хүн, малыг тоолон бүртгэдэг байсныг (Таскин 1968:40) зарим судлаачид алба, гувчуур ногдуулахаар зохион явуулж байсан арга хэмжээ гэж үзсэн нь (Доржсүрэн 1961:87, Сүхбаатар 1980:67) нэлээд ортой бололтой. Өөр нэгэн мэдээнд Хүннүд дагаар орсон хятад түшмэл Чжунхан Юэ хүн ам, мал сүрэгт татвар оногдуулах, хэрхэн бүртгэн хөтлөхийг шаньюйн шадар түшмэдүүдэд зааж сургажээ (Таскин 1968:45). Хүннүд өөрийн гэсэн албан татварын тогтолцоо байсан боловч хожим нь Юэгийн зөвлөснөөр суурин иргэдийн татварын тогтолцоо, түүнийг бүртгэн хөтлөх аргыг авч хэрэглэх болжээ. Хүннүд мал хөрөнгөгүй,

ядуурч хоосорсон нүүдэлчдийн тухай мэдээ сэлт сурвалжид тохиолдохгүй байгаа хэдий ч археологийн хэрэглэгдэхүүнээс үзвэл мал хөрөнгө хомс, ядуу хараат оршин суугчид басхүү байсан бололтой бөгөөд нүүдэлчин хүннү нарын дотор илүүдэл бүтээгдэхүүний өсөлт харьцангуй хурдан нэмэгдэж байсан нь эрх мэдэлгүй ядуу нүүдэлчин хэсэг бий болох үйл явцыг түргэтгэсэн байж болно.

Хүннүгийн нийгмийн нилээд хэсгийг дагаар орсон “албат” эзлэж байсан. Энэхүү хараат оршин суугчид нь бүтээгдэхүүнийхээ хагасаар албан тавар төлөх ёстой эдийн засаг, эрхийн хувьд хараат бүлэг юм. Гэхдээ, тэд өөрийн нийгмийн ба эдийн засгийн бүтцээ хадгалсан бөгөөд үүний нэг жишээ нь ухуань нар болно. Ухуань нар хүннүд ёрог, нэхмэл, арьс, малаар татвар төлдөг ба алба татвар хариуцсан тусгай түшмэл хураан авдаг байжээ (Доржсүрэн 1961:86). Түүнчлэн, ухуань нар хүннүгийн цэрэгт алба хаах үүрэгтэй байсан бололтой бөгөөд МЭӨ 119 онд Хан улсын цэрэг Хүннүгийн зүүн жигүүрийг довтолж, олон мянган ухуаныг олзлон авч байжээ. Ийнхүү хүннүд дотооддоо төдийгүй хараат нараас бүтээгдэхүүн ба биеэр албан татвар авах нэгдсэн тогтолцоо бий болсноор төсөөлөгдөж байна.

Хүннү нар дайн байлдаанд олзлогсдыг боол зарц болгодог. Гэхдээ энэ нь Грек, Ромын сонгодог боолчлолоос зарчмын эрс ялгаатай. Хүннү мэт нүүдэлчдийн нийгэмд боолын хөдөлмөрийг дээд зэргээр ашиглах эдийн засгийн үндэс байдаггүйтэй холбоотой бөгөөд зөвхөн гэр зуурын хүрээнд боолын хөдөлмөрийг ашиглаж байжээ. Гэхдээ, боолчлол мөлжлөгийн гол хэлбэр байхгүйгээс гадна үйлдвэрлэлд гүйцэтгэх үүрэг нь тун өчүүхэн байжээ.

Ноён уулын “Мокрый курган” хэмээх 1-р булш, мөн 6-р булшны зүүн баруун талаар нь таван жижиг хонхор байсныг Ц.Доржсүрэн малтаж үзэхэд хүн оршуулсан ул мөр болон эд өлгийн зүйл олдсоныг дурдахын хамт дунд зэргийн булшуудад ийм хонхор огт байдаггүйг тэмдэглэжээ. (Доржсүрэн 1957) Том булшуудын дагалт эдгээр жижиг булшууд бол сурвалжид дурьдсан шаньюйг нас нөхцөхөд хамт дагуулан оршуулсан хайртай зарц, шивэгчин нарын булш (Таскин 1968:40) байх ёстойгоос гадна Хүннүгийн шаньюй нарын булшийг ижил төрлийн язгууртны булшнаас ялган таних нэг гол шинж тэмдэг мөн. Үүнд үндэслэн 20х20-50х50 метр хэмжээний том булшуудыг шаньюй болон түүний ойр төрлийнхний булш гэж болохоор байна. Харин 50х50 метр том булш одоогоор мэдэгдээд буй цорын ганц том булш юм. Ийм булшийг зөвхөн хүннү улсыг үндэслэн байгуулсан Маодун шаньюй мэт их хүнд зориулсан байж болох талтай бөгөөд тэрээр умард нутагт алдаршсан домогт дайчин байсныг өмнө өгүүлсэн.

Эцэст нь эртний төр улс, нийгмийн байгуулалыг хэрхэн тодорхойлох талаар судлаачдын дунд зарим маргаан бий боловч нилээд сайн судалсан үндэслэл сайтай нь Л.Е.Куббелийн томъёолол гэж ойлгож болох юм. Тэрээр дараах гурван цогц нөхцөл байдлаар эртний нүүдэлчдийн нийгмийг тодорхойлсон байна.

1. Татвар оногдуулах систем хэлбэршин бий болсон байх, 2. Хүн амын үндсэн хэсгээс тусгаарлагдан гарсан нийтийн засаглал нь дотоод зөрчлийг хариуцсан аппараттай байх, 3. Ард түмэн овог аймгуудын хамт газар нутаг нь хуваагдсан байх гэжээ (Куббель 1988, 244-247).

Судалгаанаас үзвэл хүннүгийн нийгэмд (МЭӨ III-МЭ II зуун) дээр дурдсан гурван цогц нөхцөл байдал хэдийнээ бий болоод байсан тул түрүү төр улс гэж тодорхойлж болох юм.

МЭӨ III зуунд Төв Азийн нутагт бүрэлдэн тогтсон нүүдэлчдийн төр улс түүний аж ахуйн хөгжлийн өндөр түвшин, соёл, үзэл санаа, социал харьцаа болон засаглалын зохион байгуулалт нь нүүдэлчдийн ертөнцийг гол тодорхойлогч хүчин болж байжээ. Үүний нөлөө нь төр улсын хөгжлийн дээрх түвшинд хүрч чадаагүй хөрш овог аймаг, ард түмний дунд дэлгэрэн хожмын нүүдэлчдэд уламжлагдан нүүдэлчдийн төр улсын загвар болжээ. Ийнхүү Төв Азид соёл, иргэншлийн өвөрмөц голомт, түрүү төр улс Хүннүгийн үед үүсэн бий болсон ажээ.

**Ашигласан ном**

1. Акишев К.А, Кушаев Г.А, Древняя история саков и усуней долины реки Или. Алма-Ата. 1963.
2. Давыдова А.В. Иволгинский археологический комплекс т.2, Иволгинский могильник СПб. 1995
3. Доржсүрэн Ц. 1955 онд Төв ба баруун аймгуудад археологийн шинжилгээ, хайгуулын ажил явуулсан тухай //ШУХБ. Нийгмийн ухааны анги №2, УБ.1957
4. Доржсүрэн Ц. Умард хүннү. УБ.1961
5. Крадин Н.Н. Кочевые общества в контакте социальной эволюции. ЭО, №1, 1994
6. Куббель Л.Е. Очерки потестарно-политической этнографии. М., 1988
7. Массон В.М, Развитие элитарных структур как прогрессивный феномен скифской эпохи // Элитные курганы степей Евразии в скифо-сарматскую эпоху СПб. 1994
8. Мартынов А.И. Археология М., 1998
9. Сүхбаатар Г. Монголчуудын эртний өвөг, УБ. 1980. х.54
10. Таскин В.С. Скотоводство у сюнну по китайским источникам. Вопросы истории и историографии Китая. М., 1968
11. Таскин В.С. Тюркские названия домашних животных в языке сюннү. АН СССР. Крат сообщ. Института народов Азии. 85 М., 1964
12. Першиц А.И. Некоторые особенности классов образования и раннеклассовых отношении у кочевников-скотоводов// Становление классов и государства. М., 1976
13. Хавх Н. Нийгмийн гүн ухаан. УБ. 1996

**“To the social history of nomads”**

*by Z.Batsaikhan.*

**Summary**

In this article has been touched the issue of social history of nomads on the example Hunnus. In the 300 BC at the Central Asian region were established this nomadic state. Which has been characterized by high level of pasture farming, culture, ideology, social relations and the organization, the structure of the of the state. The determinative of nomadic power was the first Hunnu state, the our progenitor.